

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2023/06/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр аймаг
2023 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Саруул баян уул- Аудит"
ХХК Захирал: Б.Шатар
Утас: 99093852 Цахим хаяг: Shatar5626@gmail.com
Аудитор: Д.Оюунбат
Утас: 99973399 Цахим хаяг: Oyunbatdorjkhhand@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|---|-------|
| 1. Хараат бус аудиторын дүгнэлт..... | 0 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3-9 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..... | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..... | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 10 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгын өөрчлөлт..... | 11 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 12-13 |
| 4. Аудитын тайлан..... | 13 |
| 4.1 Ерөнхий зүйл | 13 |
| 4.2 Материаллаг байдал | 13 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..... | 13 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын | 14-15 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 15 |
| 5. Аудитын илрүүлэлт | 16-18 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..... | 19-20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
“БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗАР”-ЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
А.ЗУРГААНЖИН ТАНАА

2023 - 02.24 № 28

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус газар нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020106

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 89 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл / төгрөгөөр / |
|----|-------------------------------------|-----------------|-------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 8,317,514 | 3,020,472 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,293,650 | |
| 3 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 1,293,650 | |
| 4 | Төгрөг | 1,293,650 | |
| 5 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 1,291,750 | |
| 6 | Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк | 1,900 | |
| 7 | АВЛАГА | | 80,572 |
| 8 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 80,572 |
| 9 | БАРАА МАТЕРИАЛ | 3,901,598 | 2,939,900 |
| 10 | Хангамжийн материал | 3,901,598 | 2,939,900 |
| 11 | Бичиг хэргийн материал | 1,545,600 | 1,327,000 |
| 12 | Аж ахуйн материал | 2,025,500 | 1,612,900 |
| 13 | Бусад хангамжийн материал | 330,498 | |
| 14 | НӨӨЦИЙН БАРАА | 3,122,266 | |
| 15 | Бусад нөөц | 3,122,266 | |
| 16 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 168,746,017.38 | 363,462,757.86 |
| 17 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 168,746,017.38 | 363,462,757.86 |
| 18 | Биет хөрөнгө | 113,395,217.3 | 308,436,957.74 |
| 19 | Барилга, байгууламж, орон сууц | 28,164,100 | 263,446,545.93 |
| 20 | Хуримтлагдсан элэгдэл | -1,408,205.16 | -24,425,507.95 |
| 21 | Авто-тээврийн хэрэгсэл | 69,821,075 | 69,821,075 |
| 22 | Хуримтлагдсан элэгдэл | -45,087,741.73 | -50,687,741.77 |
| 23 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 91,611,363.28 | 98,973,123.28 |
| 24 | Хуримтлагдсан элэгдэл | -45,696,321.54 | -53,662,294.28 |
| 25 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,928,700 | 8,928,700 |
| 26 | Хуримтлагдсан элэгдэл | -2,937,752.55 | -3,956,942.47 |
| 27 | Биет бус хөрөнгө | 55,350,800.08 | 55,025,800.12 |
| 28 | Програм хангамж | 3,040,000 | 3,040,000 |
| 29 | Хуримтлагдсан элэгдэл | -2,389,999.92 | -2,714,999.88 |
| 30 | Бусад биет бус хөрөнгө | 58,608,000 | 58,608,000 |
| 31 | Хуримтлагдсан элэгдэл | -3,907,200 | -3,907,200 |
| 32 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 177,063,531.38 | 366,483,229.86 |
| 33 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 177,063,531.38 | 366,483,229.86 |
| 34 | Засгийн газрын хувь оролцоо | 177,063,531.38 | 366,483,229.86 |
| 35 | Засгийн газрын оруулсан капитал | 251,766,128.9 | 251,766,128.9 |
| 36 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 251,766,128.9 | 251,766,128.9 |
| 37 | Хуримтлагдсан үр дүн | -97,802,219.61 | 91,617,478.87 |
| 38 | Өмнөх үеийн үр дүн | -103,820,792.01 | -97,804,119.61 |
| 39 | Тайлант үеийн үр дүн | 6,018,572.4 | 189,421,598.48 |
| 40 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 23,099,622.09 | 23,099,622.09 |
| 41 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 177,063,531.38 | 366,483,229.86 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант огноо: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| № Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|----------------|------------------|
| 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 708,671,777.1 | 1,027,607,127.65 |
| 2 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 20,253,677.1 | 264,409,527.65 |
| 3 Нийтлэг татварын бус орлого | 20,253,677.1 | 264,409,527.65 |
| 4 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 216,089,076.03 |
| 5 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 20,253,677.1 | 48,320,451.62 |
| 6 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 688,418,100 | 763,197,600 |
| 7 Улсын төвлөрсөн төсвөөс | 587,746,400 | 747,031,100 |
| 8 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 587,746,400 | 747,031,100 |
| 9 Нэмэлт санхүүжилтийн орлого | 100,671,700 | 16,166,500 |
| 10 ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,530,000 | 1,000,000 |
| 11 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсөв хуваарилсан хөрөнгө | 86,849,800 | 15,166,500 |
| 12 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого | 1,291,900 | |
| 13 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 696,587,653.46 | 827,475,329.21 |
| 14 УРСГАЛ ЗАРДАЛ | 696,587,653.46 | 827,475,329.21 |
| 15 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 260,357,971.54 | 256,751,467.21 |
| 16 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 121,926,046 | 124,921,913 |
| 17 Үндсэн цалин | 109,799,941 | 92,548,468 |
| 18 Нэмэгдэл | 8,726,105 | 17,480,491 |
| 19 Унаа хоолны хөнгөлөлт | 3,400,000 | 11,264,000 |
| 20 Урамшуулал | | 3,628,954 |
| 21 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 17,062,549.08 | 16,859,829 |
| 22 Тэтгэврийн даатгал | 12,334,376.16 | 11,919,929.58 |
| 23 Тэтгэмжийн даатгал | 1,206,358.48 | 1,335,588.12 |
| 24 ҮОМШӨ-ний даатгал | 965,087.99 | 987,097.65 |
| 25 Ажилгүйдлийн даатгал | 223,266.49 | 269,209.41 |
| 26 Эрүүл мэндийн даатгал | 2,333,459.96 | 2,348,004.24 |
| 27 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,503,121 | 5,450,124 |
| 28 Гэрэл, цахилгаан | 337,176 | 311,274 |
| 29 Түлш, халаалт | 1,792,945 | 2,740,600 |
| 30 Цэвэр, бохир ус | 105,000 | 130,250 |
| 31 Байрны түрээс | 2,268,000 | 2,268,000 |
| 32 Хангамж, бараа материалын зардал | 31,678,121.1 | 34,205,599.02 |
| 33 Бичиг хэрэг | 6,123,000 | 3,167,262 |
| 34 Тээвэр, шатахуун | 2,268,200 | 1,874,800 |
| 35 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 529,160 | 205,160 |
| 36 Ном, хэвлэл | | 30,600 |
| 37 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,036,400 | 177,000 |
| 38 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,729,350 | 3,981,511 |
| 39 Бараа материал шилжүүлсний зардал | 14,992,011.1 | 24,769,266.02 |

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|----|---|----------------|----------------|
| 40 | Нормативт зардал | 2,692,800 | |
| 41 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,692,800 | |
| 42 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,225,900 | |
| 43 | Багаж, техник, хэрэгсэл | 15,000,000 | |
| 44 | Урсгал засвар | 2,225,900 | |
| 45 | Томилолт, зочны зардал | 138,000 | 2,059,400 |
| 46 | Дотоод албан томилолт | 138,000 | 2,059,400 |
| 47 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 45,565,136 | 2,439,800 |
| 48 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 44,779,400 | 630,000 |
| 49 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000 | 1,420,200 |
| 50 | Даатгалын үйлчилгээ | 119,250 | 124,500 |
| 51 | Тээврийн хэрэгслийн татвар | 135,750 | 131,900 |
| 52 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000 | 18,500 |
| 53 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 114,700 |
| 54 | Газрын төлбөр | 8,736 | |
| 55 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,566,298.36 | 70,814,802.19 |
| 56 | Бараа үйлчилгээний бусад зардал | 599,000 | 46,407,466.6 |
| 57 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,161,656 | 3,745,200 |
| 58 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,805,642.36 | 20,662,135.59 |
| 59 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 436,229,681.92 | 570,723,862 |
| 60 | Бусад урсгал шилжүүлэг | 414,866,423 | 519,940,160 |
| 61 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 209,778,423 | 133,300,760 |
| 62 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 204,788,000 | 385,811,400 |
| 63 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000 | 828,000 |
| 64 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 21,363,258.92 | 50,783,702 |
| 65 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,182,458.92 | 50,783,702 |
| 66 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,180,800 | |
| 67 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 12,084,123.64 | 200,131,798.44 |
| 68 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 6,065,551.24 | 10,710,199.96 |
| 69 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 6,065,551.24 | 10,710,199.96 |
| 70 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV) | 6,018,572.4 | 189,421,598.48 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 251,766,128.9 | 23,099,622.09 | -103,820,792.01 | 171,044,958.98 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 251,766,128.9 | 23,099,622.09 | -103,820,792.01 | 171,044,958.98 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | | | 6,018,572.4 | 6,018,572.4 |
| 4 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 251,766,128.9 | 23,099,622.09 | -97,802,219.61 | 177,063,531.38 |
| 5 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 251,766,128.9 | 23,099,622.09 | -97,802,219.61 | 177,063,531.38 |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -1,900 | -1,900 |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 251,766,128.9 | 23,099,622.09 | -97,804,119.61 | 177,061,631.38 |
| 8 | Тайлант үеийн үр дүн | | | 189,421,598.48 | 189,421,598.48 |
| 9 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 251,766,128.9 | 23,099,622.09 | 91,617,478.87 | 366,483,229.86 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|----|---|----------------|---------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 689,219,600 | 763,197,600 |
| 2 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 689,219,600 | 763,197,600 |
| 3 | Улсын төвлөрсөн төсвөөс | 587,746,400 | 747,031,100 |
| 4 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 587,746,400 | 747,031,100 |
| 5 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 101,473,200 | 16,166,500 |
| 6 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсөвт хуваарилсан хөрөнгө | 12,530,000 | 1,000,000 |
| 7 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсөвт хуваарилсан хөрөнгө | 87,651,300 | 15,166,500 |
| 8 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,291,900 | |
| 9 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 657,022,200 | 764,491,250 |
| 10 | УРСГАЛ ЗАРДАЛ | 657,022,200 | 764,491,250 |
| 11 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 220,792,518.08 | 193,767,388 |
| 12 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 122,456,095.08 | 124,670,448 |
| 13 | Үндсэн цалин | 91,983,049.08 | 92,770,644 |
| 14 | Нэмэгдэл | 23,189,982 | 17,473,992 |
| 15 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,283,064 | 10,796,858 |
| 16 | Урамшуулал | | 3,628,954 |
| 17 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,532,500 | 17,191,866 |
| 18 | Тэтгэврийн даатгал | 12,434,000 | 12,072,133.91 |
| 19 | Тэтгэмжийн даатгал | 1,024,600 | 1,420,673.19 |
| 20 | ҮОМШӨ-ний даатгал | 819,700 | 1,079,418.53 |
| 21 | Ажилгүйдлийн даатгал | 204,900 | 254,520.6 |
| 22 | Эрүүл мэндийн даатгал | 2,049,300 | 2,365,119.77 |
| 23 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,503,121 | 5,450,124 |
| 24 | Гэрэл, цахилгаан | 337,176 | 311,274 |
| 25 | Түлш, халаалт | 1,792,945 | 2,740,600 |
| 26 | Цэвэр, бохир ус | 105,000 | 130,250 |
| 27 | Байрны түрээс | 2,268,000 | 2,268,000 |
| 28 | Хангамж, бараа материалын зардал | 11,859,860 | 8,056,900 |
| 29 | Бичиг хэрэг | 5,364,200 | 2,575,300 |
| 30 | Тээвэр, шатахуун | 2,268,200 | 2,180,400 |
| 31 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 529,160 | 416,200 |
| 32 | Ном, хэвлэл | 183,300 | 141,700 |
| 33 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,130,800 | 696,400 |
| 34 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 384,200 | 2,046,900 |
| 35 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,503,500 | 10,000,000 |
| 36 | Багаж, техник, хэрэгсэл | 15,503,500 | 10,000,000 |
| 37 | Томилолт, зочны зардал | 138,000 | 2,061,300 |
| 38 | Дотоод албан томилолт | 138,000 | 2,061,300 |
| 39 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 46,709,436 | 2,726,700 |

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|----|---|----------------|-------------|
| 40 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45,412,300 | 630,000 |
| 41 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000 | 1,420,200 |
| 42 | Даатгалын үйлчилгээ | 119,250 | 124,500 |
| 43 | Тээврийн хэрэгслийн татвар | 135,750 | 131,900 |
| 44 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000 | 18,500 |
| 45 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 148,400 | 114,700 |
| 46 | Газрын төлбөр | 8,736 | |
| 47 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 363,000 | 286,900 |
| 48 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,090,006 | 23,610,050 |
| 49 | Бараа үйлчилгээний бусад зардал | 677,650 | 19,328,850 |
| 50 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,412,356 | 4,281,200 |
| 51 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 436,229,681.92 | 570,723,862 |
| 52 | Бусад урсгал шилжүүлэг | 414,866,423 | 519,940,160 |
| 53 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 209,778,423 | 133,300,760 |
| 54 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 204,788,000 | 385,811,400 |
| 55 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000 | 828,000 |
| 56 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 21,363,258.92 | 50,783,702 |
| 57 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,182,458.92 | 50,783,702 |
| 58 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,180,800 | |
| 59 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 32,197,400 | -1,293,650 |
| 60 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 31,486,500 | |
| 61 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 31,486,500 | |
| 62 | Дотоод эх үүсвэрээр | 31,486,500 | |
| 63 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 31,486,500 | |
| 64 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | -31,486,500 | |
| 65 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 710,900 | -1,293,650 |
| 66 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 582,750 | 1,293,650 |
| 67 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,293,650 | |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү |
|----|--|-------------|-----------------------------|-----------------|
| 1 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 747,031,100 | 696,247,398 | 50,783,702 |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 747,031,100 | 696,247,398 | 50,783,702 |
| 3 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 215,868,100 | 176,307,238 | 39,560,862 |
| 4 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 161,158,900 | 124,670,448 | 36,488,452 |
| 5 | Үндсэн цалин | 99,743,200 | 92,770,644 | 6,972,556 |
| 6 | Нэмэгдэл | 32,231,800 | 17,473,992 | 14,757,808 |
| 7 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,068,000 | 10,796,858 | 2,271,142 |
| 8 | Урамшуулал | 16,115,900 | 3,628,954 | 12,486,946 |
| 9 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,144,900 | 17,191,866 | 2,953,034 |
| 10 | Тэтгэврийн даатгал | 13,698,500 | 12,072,133.91 | 1,626,366 |
| 11 | Тэтгэмжийн даатгал | 1,611,600 | 1,420,673.19 | 190,927 |
| 12 | ҮОМШӨ-ний даатгал | 1,289,300 | 1,079,418.53 | 209,881 |
| 13 | Ажилгүйдлийн даатгал | 322,300 | 254,520.60 | 67,779 |
| 14 | Эрүүл мэндийн даатгал | 3,223,200 | 2,365,119.77 | 858,080 |
| 15 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,560,200 | 5,450,124 | 110,076 |
| 16 | Гэрэл, цахилгаан | 375,100 | 311,274 | 63,826 |
| 17 | Түлш, халаалт | 2,740,600 | 2,740,600 | 0 |
| 18 | Цэвэр, бохир ус | 176,500 | 130,250 | 46,250 |
| 19 | Байрны түрээс | 2,268,000 | 2,268,000 | 0 |
| 20 | Хангамж, бараа материалын зардал | 6,889,400 | 6,889,400 | 0 |
| 21 | Бичиг хэрэг | 1,804,300 | 1,804,300 | 0 |
| 22 | Тээвэр, шатахуун | 1,783,900 | 1,783,900 | 0 |
| 23 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 416,200 | 416,200 | 0 |
| 24 | Ном, хэвлэл | 141,700 | 141,700 | 0 |
| 25 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 696,400 | 696,400 | 0 |
| 26 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,046,900 | 2,046,900 | 0 |
| 27 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,000,000 | 10,000,000 | 0 |
| 28 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000 | 10,000,000 | 0 |
| 29 | Томилолт, зочны зардал | 469,400 | 469,400 | 0 |
| 30 | Дотоод албан томилолт | 469,400 | 469,400 | 0 |
| 31 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,736,000 | 2,726,700 | 9,300 |
| 32 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 630,000 | 630,000 | 0 |
| 33 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,420,200 | 1,420,200 | 0 |

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | |
|----|---|-------------|-------------|------------|
| 34 | Даатгалын үйлчилгээ | 124,500 | 124,500 | 0 |
| 35 | Тээврийн хэрэгслийн татвар | 131,900 | 131,900 | 0 |
| 36 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 18,500 | 18,500 | 0 |
| 37 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 114,700 | 114,700 | 0 |
| 38 | Газрын төлбөр | 9,300 | | 9,300 |
| 39 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 286,900 | 286,900 | 0 |
| 40 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,909,300 | 8,909,300 | 0 |
| 41 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,628,100 | 4,628,100 | 0 |
| 42 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,281,200 | 4,281,200 | 0 |
| 43 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 531,163,000 | 519,940,160 | 11,222,840 |
| 44 | Бусад урсгал шилжүүлэг | 531,163,000 | 519,940,160 | 11,222,840 |
| 45 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 144,323,600 | 133,300,760 | 11,022,840 |
| 46 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 385,811,400 | 385,811,400 | 0 |
| 47 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,028,000 | 828,000 | 200,000 |
| 48 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 747,031,100 | 747,031,100 | 0 |
| 49 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 747,031,100 | 747,031,100 | 0 |
| 50 | Улсын төсвөөс санхүүжих | 747,031,100 | 747,031,100 | 0 |
| 51 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 19 | 19 | 19 |
| 52 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 1 |
| 53 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 |
| 54 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 9 | 9 | 9 |
| 55 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 |
| 56 | Гүйцэтгэх ажилтан | 8 | 8 | 8 |
| 57 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 9 | 9 | 9 |
| 58 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 | 9 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | |
|---|--|--------------|
| 1 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,808,000.00 |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,808,000.00 |
| 3 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,808,000.00 |
| 4 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | |
| 5 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,808,000.00 |
| 6 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,808,000.00 |
| 7 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,808,000.00 |
| 8 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,808,000.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын үйл ажиллагааны чиглэл нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын байгууллагуудыг бодлого арга зүйгээр хангах бөгөөд тайлант жилд "Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна" гэсэн зорилгын хүрээнд 5 зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2022 онд 10 орон тоо баталж, 2 орон тоо гэрээгээр ажилласан байна.

Говьсүмбэр аймгийн боловсролын салбарын хэмжээнд ерөнхий боловсролын 5 сургууль, 7 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, 2022 онд СӨБ-д 1,518 хүүхэд, ЕБС-д 4,116 хүүхэд суралцаж, нийт 312 багш ажилласан байна.

Боловсролын чанарын үзүүлэлт сайжирч, чанарын үнэлгээгээр улсад 3 дугаар байр, ЭЕШ-ийн үнэлгээгээр 21 дүгээр байрнаас 7,10 дугаар байранд орж, түүх, нийгмийн ухаан, хими, биологийн хичээлээр улсад 1,2 дугаар байр эзэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт ГСА-2023/06/НА-СТА-ТШЗ

бичгийг мөрдлөг болгодог бөгөөд зарим нэг хууль тогтоомжийн өөрчлөлтийг эс тооцвол нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189,421.6 мянган төгрөгөөр буюу 107.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /мянган төгрөгөөр/ | | | |
|--|------------------|------------------|------------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,291.7 | 0 | -1,291.7 |
| Авлага | 0 | 80.6 | 80.6 |
| Бараа материал | 3,901.6 | 2,939.9 | -961.9 |
| Нөөцийн бараа | 3,122.3 | 0 | -3,122.3 |
| Үндсэн хөрөнгө | 168,746.0 | 363,462.7 | 194,716.7 |
| Нийт хөрөнгө | 177,061.6 | 366,483.2 | 189,421.6 |
| Засгийн газрын хувь оролцоо | 177,061.6 | 366,483.2 | 189,421.6 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 177,061.6 | 366,483.2 | 189,421.6 |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,291.1 мянган төгрөгөөр буурсан
2. Авлагын дансны үлдэгдэл 80.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажилдчаас суутгасан ХХОАТ-ыг илүү төлсөн боловч авлага үүсгээгүй тайлагнасныг аудитын явцад үүсгэсэн
3. Бараа материалын дансны үлдэгдэл 961.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны зарцуулалттай холбоотой
4. Нөөцийн бараа материалын үлдэгдэл 3,122.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны сүүлээр ирсэн сурах бичгийг бүртгэлд авч, тайлант онд сургуулиудад тараасантай холбоотой байна
5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл их хэмжээгээр нэмэгдсэн нь аймгийн ИТХ-ын 2022 оны 07 дугаар тогтоолоор Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн дансанд бүртгэлтэй 235,282.4 мянган төгрөгийн спорт заалны барилгыг шилжүүлэн авсан ба 10,000.0 төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 3027.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн.

6. Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар тогтоолоор Соёл урлагийн газарт 3,354.0 мянга, Шивээговь сумын 3 дугаар сургуульд 704.0 мянга, Баянтал сумын 4 дүгээр сургуульд 1,398.0 мянга, Сүмбэр сумын 2 дугаар сургуульд 10,000.0 мянга, нийт 15,666.0 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Боловсрол шинжлэх ухааны газар нь 2022 оны төсвийн төсөлд зардлын санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 262,877.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 262,877.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2022 онд төсвийн төслийн саналаас үйл ажиллагааны зардал 57,463.4 төгрөгөөр буурч, 205414.2 мянган төгрөгөөр батлагдаж ирсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөвт 1 удаа өөрчлөлт оруулсан ба нийт 1,481.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд: Аудит баталгаажуулалт болон тогтмол зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд нэмэгдсэн байна..

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 зорилтын хүрээнд 89 хөтөлбөр, арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 747,031.1 мянган төгрөгийг хуваарилсан байна.

Гүйцэтгэлээр 747,031.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 696,247.3 мянган төгрөг буюу 93.2 хувийг зарцуулж, 50,783.7 мянган төгрөг буюу 6.8 хувийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|----------|---|------------------|------------------|-----------------|--------------|
| | Нийт төсөв | 747,031.1 | 696,247.3 | 50,783.8 | 86.55 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны урсгал зардал | 216,896.1 | 177,135.2 | 39,760.9 | 81.67 |
| 1.1 | Цалингийн зардал | 161,158.9 | 124,670.4 | 36,488.4 | 77.36 |
| 1.2 | Шимтгэл | 20,144.9 | 17,149.9 | 2,953.0 | 85.34 |
| 1.3 | Тогтмол зардал | 5,560.2 | 5450.1 | 110.1 | 98.0 |
| 1.4 | Хангамж бараа материалын зардал | 6,889.4 | 6,889.4 | 00 | 100 |
| 1.5 | Эд хогшил худалдан авах зардал | 10,000.0 | 10,000.0 | 00 | 100 |
| 1.6 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | 2,736.0 | 2,726.7 | 9.3 | 99.66 |

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|------------|-------------------------------------|------------------|------------------|-----------------|--------------|
| 1.7 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,909.3 | 8,909.3 | 0 | 100 |
| 1.8 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,028.0 | 828.0 | 200.0 | 80.55 |
| 2 | Нийт урсгал шилжүүлэг | 530,135.0 | 519,112.1 | 11,022.9 | 91.44 |
| 2.1 | Сургуулийн өмнөх боловсрол | 134,618.4 | 125,788.0 | 8,830.4 | 93,44 |
| | Урсгал шилжүүлэг/тэтгэвэр, тэтгэмж/ | 134,618.4 | 125,788.0 | 8,830.4 | 93,44 |
| 2.2 | Ерөнхий боловсрол | 395,516.6 | 393,324.1 | 2,192.5 | 99,45 |
| | Урсгал шилжүүлэг/тэтгэвэр тэтгэмж | 395,516.6 | 393,324.1 | 2,192.5 | 99,45 |

Дээрх хүснэгтээс харахад нийт төсвийн 29.1 хувь буюу 216,896.1 мянган төгрөг нь байгууллагын үйл ажиллагааны зориулалттай, 70.9 хувь буюу 530,135.0 мянган төгрөг нь урсгал шилжүүлэг /тэтгэвэр, тэтгэмж/ байна.

Үйл ажиллагаандаа 216,896.1 мянган төгрөгийн төсөвтэйгөөс 177,135.2 мянган төгрөг буюу 81.7 хувийг зарцуулж, 39,760.9 мянган төгрөг буюу 18.3 хувийг буцаан төвлөрүүлсэн байна. Хэмнэгдсэн зардлын 99.2 хувь буюу 39,441.4 мянган төгрөг нь цалин, шимтгэлийн зардал байгаа нь 2 орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Саруул баян уул-Аудит” ХХК-ийн захирал Б.Шатар, аудитор Д.Оюунбат нар гүйцэтгэж, хяналтыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Саруул баян уул-Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 696,587.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,965.8 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80% буюу 5,572.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төсвийн үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Үйл ажиллагаандаа 216,896.1 мянган төгрөгийн төсөвтэйгөөс 177,135.2 мянган төгрөг буюу 81.7 хувийг зарцуулж, 39,760.9 мянган төгрөг буюу 18.3 хувийг хэмнэж, буцаан төвлөрүүлсэн байна. Хэмнэгдсэн зардлын 99.2 хувь буюу 39,441.4 мянган төгрөг нь цалин, шимтгэлийн зардал байна.

4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн хугацаанд нь бүрэн оруулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалт он тулгаж хийгдсэн, цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 4 | 14,836.0 | 4 | 14,836.0 | 100 |
| Нийт дүн | 4 | 14,836.0 | 4 | 14,836.0 | 100 |

Өмнөх аудитаар 14,836.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.